



**ХӨШИГИЙН ХӨНДИЙН
НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК**
Төрийн Өмчиг Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3, Компанийн дүрмийн долдугаар зүйлийн 7.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын долдугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн “Ажил төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэн батлагдсан журмын дагуу ажлаа төлөвлөж, тайлагнаж ажиллахыг нийт ажилтан нарт, ажилтнуудын ажлыг бодитой үнэлж, дүгнэн ажиллахыг хэлтэс, албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Захиргаа удирдлагын хэлтэс /С.Батчимэг/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЦЭНГҮҮНЖАВ

001136